



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/21

Хэрлэн сум

Үнэлгээний хороо бэйгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөл, Батноров сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Онцгой байдлын газрын авто гражын барилга угсралтын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Г.Лхагвахатан Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Н.Үнэнбат Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Б.Содбилэг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн  
Ж.Даваасүрэн Төрийн бус байгууллагын төлөөлөл  
Д.Оюун Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга ( Г.Лхагвахатан )-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010123